МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 20 өдөр Дугаар А/106 Мөрөн сум

Захирамжид өөрчлөлт оруулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2008 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн №214 дүгээр захирамжийн холбогдох хэсэгт газар эзэмшигч хуулийн этгээд "Анунхангай" ХХК (РД:5004225)-ын Мөрөн сумын 5 дугаар багт байршилтай "Далай ээж-2"-ын 205 тоот хаягтай, худалдаа, нийтийн үйлчилгээний зориулалттайгаар эзэмшүүлсэн 6712012624 нэгж талбарын дугаартай газрын талбайн хэмжээ 400м2 гэснийг 410м2 гэж өөрчилж үлдсэн 1 жилийн хугацаагаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2008 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн №214 дүгээр захирамжийн холбогдох хэсгийг хүчингүй болгосугай.

3. Газар эзэмшигч хуулийн этгээд "Анунхангай" ХХК (РД:5004225)-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т, Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул)-т тус тус зөвшөөрсүгэй.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай)-т үүрэг болгосугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

6712010457